

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2022 оны 03 дугаар сарын 26-ны өдөр

№ 22/01

Улаанбаатар хот

**Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалтыг тус тус удирдлага болгон Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2022 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн 2021 оны үйл ажилаагааны болон санхүүгийн тайлангийн талаар “Хангалттай” гэж дүгнэсэн Компанийн ТУЗ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталсугай.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДАРГА**



Б.УДВАЛ

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2022 оны 03 дугаар сарын 26-ны өдөр

№ 22/02

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
зарим гишүүдийг улируулан сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дах заалт, 77 дугаар зүйлийн 77.1 болон 77.2 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (“Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.7, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалт, 2022 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дараах гишүүдийн бүрэн эрхийн хугацааг 1 (нэг) жилээр сунгаж, улируулан сонгосугай.
 - 1.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн:
 - 1.1.1. Монгол Улсын иргэн Очирсүрэн овогтой Болдбаатар;
 - 1.1.2. Монгол Улсын иргэн Володьяа овогтой Баярсайхан;
 - 1.1.3. Монгол Улсын иргэн Сэнгээ овогтой Энх-Амгалан;
 - 1.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн:
 - 1.2.1. Монгол Улсын иргэн Сүрэнхүү овогтой Боргил;
 - 1.2.2. Монгол Улсын иргэн Жигдэн овогтой Жаргалсүрэн.
2. Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн Үйл ажиллагааны журам болон бусад Компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг улиран сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдэд үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн даргад даалгасугай.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДАРГА**



**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2022 оны 03 дугаар сарын 26-ны өдөр

№ 22/03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1 болон 77.2 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (“Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.7 дахь заалт, 2022 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр Даваасамбуу овогтой Галхүүг сонгосугай.
2. Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3-т заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 1 (нэг) жил буюу дараа жилийн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл үргэлжлэхийг дурдсугай.
3. Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бусад Компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Даваасамбуу овогтой Галхүүд үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн даргад даалгасугай.



**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2022 оны 03 дугаар сарын 26-ны өдөр

№ 22/04

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүд сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1 болон 77.2 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (“Компани”)–ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.7 дахь заалт, 2022 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр
 - 1.1 Монгол Улсын иргэн Баатархүү овогтой Хос-Эрдэнэ;
 - 1.2 Монгол Улсын иргэн Цэрэндорж овогтой Ууганбаяр;
 - 1.3 Монгол Улсын иргэн Болд овогтой Итгэл нарыг сонгосугай.
2. Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3-т заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 1 (нэг) жил буюу дараа жилийн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл үргэлжлэхийг дурдсугай.
3. Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн Үйл ажиллагааны журам болон бусад Компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдэд үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн даргад даалгасугай.



**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2022 оны 03 дугаар сарын 26-ны өдөр

№ 22/05

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны төсвийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (“Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.11 дэх заалт, 2022 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны төсвийг энэхүү тогтоолын Нэгдүгээр хавсралтад заасны дагуу баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгасугай.

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДАРГА**



Б.УДВАЛ